

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙГ 2010 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

2011.03.16

Монгол улсын эдийн засаг нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн аймаг орон нутагт хэрэгжүүлэх нийт 54 зорилтот арга хэмжээнд Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолын дагуу хяналт шинжилгээ хийхэд биелэлтийн дундаж хувь 94,1 хувь буюу 4.6 оноотой байна. **ХАВСРАЛТ 5**

Аймгийн Засаг даргын 2010 оны 56 дугаар захирамжаар төсөл сонгон шалгаруулах дэд комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилж, 2010 онд ЖДҮ-ийн хүрээнд хэрэгжүүлэх 13 чиглэлийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлуулан нийт 816 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон нь аймгийн хэмжээнд ажлын байр шинээр бий болох, ЖДҮ-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээнд тодорхой ахиц гарахад нөлөөлсөн байна.

Мөн сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн цогцолбор аж ахуй бий болгох, махны чиглэлийн үхэр, хонины цогцолбор аж ахуйг шинээр байгуулахад нь зориулж 21 иргэн, аж ахуйн нэгжид 5,0-40,0 сая төгрөгийн зээл тус тус олгосон байна. "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2", "Сүү" үндэсний хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна.

Гол мөрний бохирдлыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлж, булаг шанд, гол горхины эхийг хамгаалах, хөв цөөрөм байгуулах, бүх нийтээр мод тарих зэрэг ажлуудыг сайн зохион байгуулсан байна.

Хүний хөгжил сангаас олгож байгаа иргэн бүрт хишиг хувь хүртээх ажлын явц 94,3 хувьтай явагдаж байгаагийн зэрэгцээ 2010 онд малгүй болсон буюу малаа их хэмжээгээр хорогдуулсан малчин 20 өрхөд Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслөөс 80 сая төгрөгийн 1603 толгой бог мал олгосон байна.

Зорилт, арга хэмжээнүүдээс 1.16.5 "Арьс шир" дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь тус аймагт арьс шир боловсруулах анхан шатны үйлдвэр байгуулагдаагүй байгаатай холбоотой байна. Мөн мэргэжлийн хяналтын байгууллага хяналтын хуудас боловсруулж ашиглах, зөвхөн хяналтын хуудсанд заагдсан асуудлын хүрээнд хяналт шалгалт хийх асуудал удаашралтай, зөвхөн 1 сургагч багш бэлтгэх хэмжээнд хэрэгжиж байгаа нь учир дутагдалтай байна. Бусад зорилтот арга хэмжээнүүд хяналт шинжилгээний дүнгээр 90-100 хувийн биелэлттэй байгаа нь 2010 оны үндсэн чиглэлийн зорилтууд амжилттай хэрэгжсэнийг харуулж байна.